

БАТЛАВ.
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.БАЯРБАТ

**“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН ЭХНИЙ ЭЭЛЖИЙН АВТО ЗАМ,
ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 05 дугаар сарын 10

Дугаар 2024/06

Улаанбаатар хот

1.	Үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг “Хархорум хотыг сэргээн байгуулах тухай”;- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол “Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай”;- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль;- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо байгуулах тухай;- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 21 дүгээр тогтоол, “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай”;- Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хорооны даргын баталсан “Шинэ Хархорум” хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2025);- Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тушаал;
2.	Байршил	Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт
3.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2 тэрбум 178 сая төгрөг
4.	Авто замын ангилал, замын зэрэг	1. Хотын 1-р зэрэглэлийн гол зам /30 км, нэг талдаа 4-өөс багагүй эгнээ, давхар 2 эгнээ дублер замтай төлөвлөх/; 2. Хотын 1-р зэрэглэлийн туслах зам /20 км, 4-өөс багагүй эгнээ зам төлөвлөх/; (“Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-тэй уялдуулах)
5.	Замын эхлэлийн цэг	1. А0601 чиглэлийн авто замаас эхлэх (Зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх); 2. А28 чиглэлийн авто зам /Хархорин сум/ орчмын цэгээс эхэлнэ (Зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх);

		Замын трассыг “Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-тэй уялдуулах
6.	Замын төгсгөлийн цэг	1. А28 Өгий нуур чиглэлийн авто замтай холбох (Зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх); 2. А28 Өгий нуур чиглэлийн авто зам /Онгоцон хөндий/ орчмын цэг хүртэл (Зам тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх);
7.	Замын хучилтын хийц	Техникийн шийдэл, тооцоогоор сонгох
8.	Төлөвлөлтийн норм	<ul style="list-style-type: none"> - “Авто зам төсөллөх” /ЗЗБНБД 22-004-2016/; - “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” /ЗЗБНБД 81-013-2019/; - “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” /БНБД 30.01.04/; - “Ус зүйн тодорхойлолтыг тооцоолох норм ба дүрэм” /БНБД 2.01.14-86/; - “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” /БНБД 22.01.01/; - “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” /БНБД 11-07-04/-ийн II хэсэг инженер геодезийн ажил; - “Геодезийн ажил” /БНБД 3.01.03-88/; - “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” /БНБД 32-02-12/; - “АЗУГН” /2.01.01-2004/; - “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” /БД81-104-02/; - “Авто зам, гүүр, инженерийн хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал” /БД 22-104-18/; - “Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм” /БД 30-102-11/; - “Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм” /БД 40-302-13/; - “Авто зам болон төмөр замын геодезийн ажил” /БД 11-114-14/; - Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм; - “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” /MNS 4597-2014/; - “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” /MNS 4596-2014/;

		<ul style="list-style-type: none"> - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” /MNS 6056-2009/; - “Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага” /MNS 6808-2019/; - Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага /MNS 4598-2020/; - “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000” /MNS 6736-2018/; - “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал”; - Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах; <p>ЗТХ-н Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”, бусад шаардлагатай хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол улсын холбогдох ЗЗБНБД, БНБД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.</p>
9.	Зураг төсөл гүйцэтгэх хугацаа, үе шат	<p>2 үе шаттай. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулж 120 хоногийн хугацаанд ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>1. Техникийн зураг төсөл /30 хоног/;</p> <p>2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл /90 хоног/;</p> <ul style="list-style-type: none"> - Инженер геодезийн ажлын тайлан; - Инженер-геологийн судалгааны ажлын тайлан; - Авто зам замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл; - Зургийн тайлбар бичиг (ус зайлуулах болон инженерийн байгууламжийн тооцоо, хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, холбогдох захирамж, техникийн нөхцөлүүд); - Техникийн шаардлага; - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв; - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсан байх;
10.	Зураг төслийн иж бүрдэл	<p>Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:</p> <ul style="list-style-type: none"> - “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” /БНБД 11-07-04/-ийн II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” /БНБД 3.01.03-88/-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан; - Тухайн авто замыг барьж бүрэн дуусгахад шаардлагатай (Нийтийн тээвэрт зориулсан түр зам, газрын өнгөн хөрс хуулах, ус өнгөрүүлэх хоолой ба ус

		<p>зайлуулах бусад байгууламж, гүүр, ул хөрс солих, цэвдгийг гэсэлтээс хамгаалахад зориулсан дулаан тусгаарлах ба чулуун асгасан үе, шороон далан, ухмал, далангийн дээд үе, тусгай үеүд, суурийн дэвсгэр үе, замын суурь ба хучлага, ан амьтныг хөндлөн гаргах байгууламж, замын тоноглол, бетон барьер, хөдөлгөөн зохицуулалтын ба аюулгүй байдлын хэрэгслүүд, тэмдэг ба тэмдэглэл, зогсоол ба амрах талбай, зам, гүүрийн барилгын зурваст орсон шилэн кабелийг хамгаалах, цас хунгарлалтыг багасгах хэрэгсэл зэрэг) бүх төрлийн ажлын (гэхдээ эдгээрээр зөвхөн хязгаарлагдахгүй) нарийвчилсан зураг;</p> <ul style="list-style-type: none"> - Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх ажлын техникийн шаардлага (ТШ); - Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх төрлийн ажлын болон барилгын нийт ажлын тоо хэмжээний жагсаалт (АТХЖ); - Авто замын өртгийн Инженерийн нарийвчилсан тооцоо (ИНТ); - Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ); - Байр зүйн судалгааны болон геодезийн хэмжилтийн ажлын дэлгэрэнгүй тайлан; - Геоморфолог, гидрогеологи, геотехникийн болон материалын олдцын судалгааны дэлгэрэнгүй тайлан; - Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлангаас бүрдэнэ; - Авто зам, гүүрийн зурваст орсон инженерийн байгууламж, цахилгаан холбоо, дулаан, шилэн кабелийн шугам сүлжээний зураг төсөл, техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, авто замын трасст орсон иргэн аж ахуй нэгжийн газар чөлөөлөх (газар, объект), нүүлгэн шилжүүлэх ажлын судалгаа гаргах, ажлын тоо хэмжээ, зардал; - Авто замын барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд; - Дэвсгэр зураг, дагуу огтлол, хөндлөн огтлол, уулзварын огтлол, бүтээц хэсэглэлийн зураглал; - Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл; - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт; - Зураг төслийг Монгол, Англи хэл дээр боловсруулна;
11.	Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
12.	Захиалагч байгууллага	Барилга, хот байгуулалтын яам

13.	Онцгой нөхцөл	<p>Зураг төслийн онцгой нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> - Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох баримт бичгийг эх хувь 1ш, хуулбар 3ш /хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/, тоон хэлбэрээр /*.dwg, *.shp, *.pdf, *.docx, *.pptx/ - Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, зогсоол хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ гэх мэт) Layer тус бүрээр нь салгаж Autocad /*.dwg/ файлаар өгөх; - Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Дэвсгэр зураг 1:500 • Замын байгуулалт 1:100 • Дагуу огтлол - хэвтээ 1:500 • Дагуу огтлол - босоо 1:100 • Хөндлөн огтлол 1:100 • Уулзвар, огтлолцол 1:500 • Бүтээц хэсэглэл 1:20 • Зам, гүүрийн байгууламж 1:100 - Судалгааны ажлын явцад түүх, археологи, соёлын өв, архитектурын дурсгалд хамаарах дурсгал илэрсэн тохиолдолд түүнийг хадгалах, хамгаалах, нарийвчлан судлах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж, дүгнэлтийг боловсруулах; - Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /төслөөр/, уулзвар төлөвлөлт, гэрлэн дохио, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, явган хүний гарц /нэг болон хоёр түвшин гарцыг төслөөр/, ногоон байгууламж, тусгаарлах зурвас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх, план зурагт инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулах; - А0601 чиглэлийн улсын чанартай авто замтай холбогдох уулзвар гарцыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тасралтгүй жигд хуваарилах олон түвшний огтлолцлоор төлөвлөх; - А0601 чиглэлийн авто замаас А28 руу салаалах шинээр төлөвлөж буй авто замд болон шаардлагатай тохиолдолд дайран өнгөрч буй төв суурин газруудад тойрог уулзвар төлөвлөх;
-----	---------------	---

		<ul style="list-style-type: none"> - Зайлшгүй шаардлагатай тохиолдолд олон улсад түгээмэл хэрэглэгддэг зохих стандарт, нормыг захиалагчтай зөвшилцөж ашиглаж болно; - Уулзвар, гарц, одоо байгаа замын огцом налуу болон эргэлт бүхий хэсгүүд зэрэг хэсгүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, цогц арга хэмжээг төлөвлөх; - Халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх; - Мал амьтны зам хөндлөн гарах магадлал бүхий цэгүүдийг судалгаагаар тогтоож, мал амьтан авто замыг хөндлөн гарах хоёр түвшний гарц төлөвлөх; - Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх инженерийн шийдлийг төсөллөх; - Замын дагууд замын үйлчилгээний байгууламжийн ерөнхий төлөвлөх, боломжтой газруудыг судалж, төсөллөх, холбогдох санал үндэслэлийг ИДТ-д тусгах; - Замын дагууд үйлчилгээний байгууламж, холбогдох норм дүрмийн дагуу амрах талбай, түр зогсоол төсөллөх; - Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; - Суурин газруудад гэрэлтүүлэг болон цахилгаан хангамж, явган хүний аюулгүй байдлыг хангасан гарц, гэрлэн дохио суурилуулахаар төсөллөх; - Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах; - Тухайн газар орны газрын гадаргуугийн зураг, үндсэн репцрийн сүлжээ, элемент тус бүрийн төсөллөлтөд ашигласан шалгуур үзүүлэлтүүд, анхны төсөөлөл, загвар, хэрэглэсэн арга, тооцооллын хураангуй, материалын туршилтын үр дүн зэргийг хамруулан, цуглуулсан бүх өгөгдлийг ИДТ-д хавсралт болгон тусгана; - Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрд хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох; - Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох; - Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх; - Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, орох гарцын шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх;
--	--	---


		<ul style="list-style-type: none"> - Гадаргуугийн ус зайлууллатыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх; - Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, авто замын трассын дагууд суваг, шуудуу, жалга дайрсан үед шаардлагатай тохиолдолд гүүр, гүүрэн гарц, хоолой төлөвлөх; - Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах; - Авто замын трассаг орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах; - Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх; - Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх; <p>Зураг төслийн ажлын үйл явцын онцгой нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар"-аас геодезийн өндөржилтийн цэгийг авах бөгөөд замын трассын дагуу хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн ажлын тайланг тус газарт хүргүүлж, бүртгүүлсэн тухай албан бичгийг ИДТ-д хавсаргах; - Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгууламж, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох; - Замын эхлэл, төгсгөлийн цэгийг Захиалагч байгууллагатай зөвшилцөж, авто замын салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, зөвлөмж гаргана; - Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлого хэрэгжилтийг зохицуулах газраас санал авч шаардлагатай тохиолдолд төлбөр хураах цэгийн барилгын зураг төслийг хийх; - Замын трасст орсон өндөр хүчдэл, агаарын шугам, цахилгаан, дулаан, холбооны шугам сүлжээ, шилэн кабелийг зөөх, шилжүүлэх, хамгаалах ажлын
--	--	---

		<p>нарийвчилсан зураг төсөл, нүүлгэн шилжүүлэх ажлын төсөв гаргаж баталгаажуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглолын зураг төслийг нарийвчлан боловсруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг аудит хийлгэх; - Төсөллөлтийг гүйцэтгэхдээ шаардлагатай тохиолдолд захиалагчтай зөвлөлдөж, Инженерийн нарийвчилсан зураг боловсруулахтай холбогдолтой бүх асуудлыг инженерийн дэлгэрэнгүй тайланд бүрэн тусгана; - Трасс сонголтыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, инженерийн шугам сүлжээ, одоо байгаа барилга байгууламж, хэтийн хөдөлгөөний эрчмийг анхаарч үзэх; - Гудамж замын төлөвлөлтийн талаар танилцуулга, мэдээллийг тайлбар бичигт тусгах, захиалагч байгууллагад урьдчилан танилцуулах; - Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах; - Зөвлөх нь бүх өгөгдөл, инженерийн нарийвчилсан зураг, баримт бичгийн үнэн зөв, иж бүрдлийг бүрэн хариуцах бөгөөд шаардлагатай бол барилгын ажлын тендер шалгаруулалтын үед зохих тодруулгыг өгнө; - Авто зам төлөвлөлтийн шатанд захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах; - Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж “замын мэдээллийн сан”-д оруулах, баталгаажуулах; - Зам тээврийн хөгжлийн яамны мэргэжлийн зөвлөл болон холбогдох шатны бусад байгууллагуудтай зөвшилцөх; - Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг Захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлал хийлгэх; - ЗТХ-н Сайдын 2018 оны 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-н 9.2 “Хийц, технологийн онцлог, түвэгшилттэй шийдэл бүхий авто зам, замын байгууламжийн бүрдэл хэсгийн нарийвчилсан зураг төсөлд хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлал хийж болно” заалтын дагуу хэсэгчлэн магадлал хийх боломжтой;
--	--	---

		<p>9.3.4 “Томоохон хэмжээний зураг төслийн ажил эсвэл хийц технологийн онцлог шийдэл бүхий зураг төсөлд магадлал хийх ажилд “экспертүүдийн баг”-ийг зураг төслийн хайгуул, судалгааны шатанд томилон ажиллуулж, зураг төслийн ажлын үе шат бүрт хяналт тавих замаар магадлалын ерөнхий дүгнэлтийг хэсэгчлэн гаргуулах” заалтыг зураг төслийн ажлын үйл явцад баримтлана;</p> <p>- Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх;</p>
--	--	---

ЗӨВШӨӨРСӨН:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТБОЛД

“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ДАРГА



Н.НАЦАГДОРЖ

ХЯНАСАН:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ



Д.БЭЛЭГСАЙХАН

“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ХОСБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



А.СУГАР

“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ХОТ, СУУРИН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ЭНЭРЭЛ